



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

383. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 82 3111

384. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 83 3112

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

385. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 49 3113

386. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 51 3113

387. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 52 3114

388. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 53 3114

389. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 54 3115

390. Элчин сайдыг тохоон томилох тухай Дугаар 55 3115

391. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 56 3116

392. Засгийн газарт чиглэл өгөх тухай Дугаар 58 3116

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

393. Оюуны өмчийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай Дугаар 151 3318

394. Журам батлах тухай Дугаар 160 3123







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал Байнгын хорооноос гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

УКЖТ НОЛГУ 09 ДАЛО) Т  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГЭВ. [660662196\*.Т

НЭӨЛ1 ЗУМБДСЦ11666С1 40 Т-ЫНО ВСХДЗСОДЫН1

НОЛ1190ДӨВ 40 ФОЛОНСӨНӨСӨС КЭЖКЭ9 09 ФОНЖКМ ДЫЛ11929 Д19

10НӨГ1 КЭЗЭЗ ЗУМБД ДННӨДӨ 119 НОЛ119А ФСЗ ГЭЛДӨМӨСӨС 1 ИЖКӨД1929

ФОНЖКЦ11619 ФОЛОНӨНО ДӨМӨӨ1 НӨӨЛ1 119 Д0120Х 1 ВСХДӨӨНО ФАНО

1МОНЦ\* 09 Д-КЖТ ДЭКЭ1 ДННӨГ 1 НӨӨДӨӨНО ДӨМӨӨ1 НӨӨЛ1 40

ФОЛОНӨНО ДӨМӨӨ1 НӨӨЛ1 119 Д0120Х ДӨ1 НЫМНО Д-КЭЗ ИЖКӨК1929

1ЭСЭ ( 09 ГЭЛ1\* 09 ДӨМӨӨ1 НӨӨЛ1 40 ИМЫН19\* ФОНЖКЦ11619

ИМЫН19\* ФОНЖКЦ11619 ФОЛОНӨНО ДӨМӨӨ1 МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ФОНТ 09 1ЭСЭ ( 09 ГЭЛ1\* 09 В1Ц11190КЭЗ 0 ДӨМӨӨ1 НӨӨЛ1 40

НӨӨЛ1 40 ИМЫН19\* ФОНЖКЦ11619 ФОЛОНӨНО ДӨМӨӨ1 МОНГОЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГЭВ. [660662196\*.Т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГЭВ. [660662196\*.Т

10 090ДӨ\* 26\*.Т 119 14 - 0 Ф00\* Ф010 09 УКЖТ НОЛГУ 40 Д-КЭЗ

1 МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГЭВ. [660662196\*.Т

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619

ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619 ФОНЖКЦ11619



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 47 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн шүүгч Дамдинжавын Мөнхцэцэгийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Шараагийн Эрдэнэцэцэгийг Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батлайн Чулуунхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдинсүрэнгийн Даваасүрэнг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад хавсран суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригтын Чингүшигийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шижээхүүгийн Одонбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сүрэнгийн Цоггэрэлийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанцэрэнгийн Эрдэнэдавааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дашийн Билэгдоржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жигжээгийн Сэрээжавыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содномын Ганхуягийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гончигийн Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбажавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай:

1.1. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад Монгол Улсын хувь нэмэр, бодит оролцоог нэмэгдүүлэх, “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх үндэсний цогц хөтөлбөр, стратеги гарган хэрэгжүүлэх;

1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах;

1.3. Ойн салбарын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах төрийн захиргааны байгууллага болох Ойн агентлаг болон төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан засаглал, үр нөлөөтэй удирдлагын тогтолцоо бүхий ойн аж ахуйн нэгжийг байгуулж, санхүүгийн зохистой механизмыг бүрдүүлэх;

1.4. Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах зорилгоор агро-ойг хөгжүүлж, иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгох, иргэн, аж ахуйн нэгжид татварын болон татварын бус бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, халамжаас-хөдөлмөрт шилжих цогц бодлоготой мод тарьж ургуулах бүх нийтийн үйлсийг уялдуулах;

1.5. Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн сан бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах зээлийн эргэлтэд оруулж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх;

1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох;

1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах;

1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлог тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх;

1.9. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд байгаль орчноо хайрлан хамгаалах монгол зан заншлыг дээдлэх, экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллагын онцлог тохирсон хэлбэрээр сургалт, соён гэгээрүүлэх хөтөлбөрөөр хэрэгжүүлэх.



2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмрээ оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.

3. Энэ зарлигийг хэрэгжүүлэхтэй холбогдон Засгийн газраас гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгах, зарлигийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгч болон олон нийтэд улирал тутам мэдээлж байхыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**ЛУВСАННАМСРАЙН  
ОЮУН-ЭРДЭНЭ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 5 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 151

Улаанбаатар  
хот

### **Оюуны өмчийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай**

Оюуны өмчийн тухай хуулийн 24.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Оюуны өмчийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 199 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”-ний 24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Х.НЯМБААТАР**



Засгийн газрын 2021 оны 151 дүгээр  
тогтоолын хавсралт

ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГААС ҮЗҮҮЛЭХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

№	Оюуны өмчийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний нэр	Үйлчилгээний хөлсний хэмжээ (төгрөг)
Нэг. Патентын үйлчилгээ		
1.1.	Шинэ бүтээлийн патентын цаасан мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -5 томьёололтой мэдүүлэг -5-аас дээш томьёолол тус бүрд	35,000 5,000
1.2.	Ашигтай загварын патентын цаасан мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх, шүүлт хийх -5 томьёололтой мэдүүлэг -5-аас дээш томьёолол тус бүрд	25,000 5,000
1.3.	Мөн чанарын шүүлт хийх -5 томьёололтой мэдүүлэг -5-аас дээш томьёолол тус бүрд	40,000 5,000
1.4.	Орчуулга ирүүлэх хугацааг сунгуулах	20,000
1.5.	Эрх шилжүүлсэн акт, зохиогчийн баталгаа, итгэмжлэлийг ирүүлэх хугацааг сунгуулах	15,000
1.6.	Мэдүүлэг гаргаснаас хойш давамгайлах эрх хүсэх	20,000
1.7.	Давамгайлах огноог нотлох баримт ирүүлэх хугацааг сунгуулах	15,000
1.8.	Нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлэх хугацааг сунгуулах	20,000
1.9.	Нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлэх	15,000
1.10.	Бүрдлийн шүүлтийн явцад нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлэх хугацааг сунгуулах	15,000
1.11.	Патентын мэдүүлэгт өөрчлөлт оруулах	25,000
1.12.	Хайлтын тайланг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулах хугацааг сунгуулах	25,000
1.13.	Шүүлтийн тайланд хариу ирүүлэх хугацааг сунгуулах	15,000
1.14.	Бүтээгдэхүүний загварын цаасан мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх, шүүлт хийх -5 хувилбартай мэдүүлэг -5-аас дээш хувилбар тус бүрд	35,000 3,000
1.15.	Улсын бүртгэлд бүртгэж, патент олгох	25,000
1.16.	Патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамж төлөх хугацааг сэргээх хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх	30,000



1.17.	Мэдүүлэг гаргагч, эсхүл патент эзэмшигчийн нэр, хаяг өөрчлөх, эзэмшигчийн эрх шилжүүлэх	25,000
1.18.	Патентын лицензийн гэрээг бүртгэх	35,000
Хоёр.Барааны тэмдэг, газар зүйн заалтын үйлчилгээ		
2.1.	Барааны тэмдгийн цаасан мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	50 000 5,000
2.2.	Гэрчлэх тэмдэг, хамтын тэмдгийн цаасан мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	55,000 5,000
2.3.	Барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах тухай урьдчилсан шийдвэрт хариу ирүүлэх хугацааг сунгуулах	15,000
2.4.	Эсэргүүцэл гаргах хугацааг сунгуулах	30,000
2.5.	Газар зүйн заалтын цаасан мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	55,000 5,000
2.6.	Барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээ олгох	30,000
2.7.	Барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	40,000 3,000
2.8.	Барааны тэмдэг эзэмшигчийн эрх шилжүүлэх, нэр, хаягийн өөрчлөлт хийх, ангилал болон бараа үйлчилгээний нэрсийн жагсаалтаас хасалт хийх	40,000
2.9.	Газар зүйн заалтын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах	25,000
2.10.	Олон улсын мэдүүлгийг хянаж, гэрчлэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	40,000 5,000
2.11.	Барааны тэмдгийн лицензийн гэрээг бүртгэх	25,000
2.12.	Барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцуулах тухай хүсэлт хүлээн авч, хянан шийдвэрлэх	5,000,000
2.13.	Барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцож, гэрчилгээ олгох	5,000,000
Гурав.Зохиогчийн эрхийн үйлчилгээ		
3.1.	Зохиогчийн эрхийн бүтээл бүртгүүлэх хүсэлтийг цаасаар өгөх	50,000
3.2.	Зохиогчийн эрхийн гэрчилгээ олгох	15,000



Дөрөв.Маргаан шийдвэрлэх зөвлөлийн үйлчилгээ		
4.1.	Маргаан шийдвэрлэх зөвлөлийн үйлчилгээ	200,000
Тав.Оюуны өмчийн мэдээллийн сангаас лавлагаа, хуулбар олгох болон бусад үйлчилгээ		
5.1.	Улсын бүртгэл, мэдүүлгийн бүртгэлтэй холбоотой лавлагаа гаргаж өгөх	20,000
5.2.	Үрэгдүүлсэн патент, гэрчилгээг нөхөн олгох	30,000
5.3.	Бусад гэрээг бүртгэх	25,000
5.4.	Бүртгэлд засвар оруулах, шинээр патент, гэрчилгээ олгох	15,000
5.5.	Эх баримтаас хуулбар олгох	100 (нэг хуудас)
5.6.	Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөл олгох	65,000
5.7.	Оюуны өмчийн үнэлгээчин болон зуучлагчийн бүртгэлийн үйлчилгээ	100,000
5.8.	Барааны тэмдгийн мэдүүлгийг яаралтай журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргах	300,000
Зургаа.Цахим үйлчилгээ		
6.1.	Шинэ бүтээлийн патентын цахим мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -5 томъёололтой мэдүүлэг -5-аас дээш томъёолол тус бүрд	25,000 5,000
6.2.	Ашигтай загварын патентын цахим мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх, шүүлт хийх -5 томъёололтой мэдүүлэг -5-аас дээш томъёолол тус бүрд	15,000 5,000
6.3.	Бүтээгдэхүүний загварын цахим мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх, шүүлт хийх -5 хувилбартай мэдүүлэг -5-аас дээш хувилбар тус бүрд	25,000 3,000
6.4.	Барааны тэмдгийн цахим мэдүүлэг хүлээн авч, бүртгэх мэдүүлгийн бүртгэлд -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	40,000 5,000
6.5.	Гэрчлэх тэмдэг, хамтын тэмдгийн цахим мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	45,000 5,000



6.6.	Газар зүйн заалтын цахим мэдүүлэг хүлээн авч, мэдүүлгийн бүртгэлд бүртгэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	45,000 5,000
6.7.	Барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх -3 ангилалтай (бараа, үйлчилгээний) -3-аас дээш ангилал тус бүрд	30,000 3,000
6.8.	Барааны тэмдэг эзэмшигчийн эрх шилжүүлэх, нэр, хаягийн өөрчлөлт хийх, ангилал болон бараа үйлчилгээний нэрсийн жагсаалтаас хасалт хийх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх	30,000
6.9.	Зохиогчийн эрхийн бүтээлийг цахимаар бүртгэх	25,000
6.10.	Цахим патент, гэрчилгээ олгох	Үнэгүй
6.11.	Шинэ бүтээлийн цахим сангаас хайлт хийж, мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.12.	Ашигтай загварын цахим сангаас хайлт хийж, мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.13.	Барааны тэмдгийн цахим сангаас хайлт хийж мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.14.	Бүтээгдэхүүний загварын цахим сангаас хайлт хийж, мэдээлэл лавлагаа авах	Үнэгүй
6.15.	Зохиогчийн эрхийн цахим сангаас хайлт хийж, мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.16.	Шинэ бүтээлийн цахим сангаас мэдүүлгийн төлөв байдлын талаар мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.17.	Ашигтай загварын цахим сангаас мэдүүлгийн төлөв байдлын талаар мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.18.	Барааны тэмдгийн цахим сангаас мэдүүлгийн төлөв байдлын талаар мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй
6.19.	Бүтээгдэхүүний загварын цахим сангаас мэдүүлгийн төлөв байдлын талаар мэдээлэл, лавлагаа авах	Үнэгүй

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 6 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 160

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 10.1.13-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг 2021 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**САНГИЙН САЙД**

**Б.ЖАВХЛАН**

Засгийн газрын 2021 оны 160 дугаар  
тогтоолын хавсралт

### **ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

#### **Нэг.Нийтлэг үндэслэл**

##### **1.1.Зорилго, хамрах хүрээ**

1.1.1.Энэ журмын зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон санхүүжилтийн удирдлагыг боловсронгуй болгох замаар төсвийн зардлыг бууруулж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

1.1.2.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх



төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах харилцааг энэ журмаар зохицуулна.

1.1.3. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй аливаа хөрөнгө оруулалт, концессын гэрээний эргэн төлөлт, улсын төсвийн бүрэлдэхүүнд ордог Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад энэ журмыг мөрдлөг болгоно.

1.1.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж энэ журмын хэрэгжилт, зохион байгуулалтыг хангаж ажиллана.

## 1.2. Хууль, эрх зүйн орчин

1.2.1. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Концессын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ (цаашид “төсөл” гэх)-ний төлөвлөлтөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталж мөрдүүлэх дараах журам, аргачлалыг удирдлага болгоно:

1.2.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам;

1.2.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал;

1.2.2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал;

1.2.2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал.

1.2.3.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем” (цаашид “цахим систем” гэх) гэдэгт төслийг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, мэдээллийг хадгалах зориулалт бүхий цахим системийг ойлгоно.

1.2.4.Энэ журамд дурдсан нэр томьёог холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тодорхойлж, тайлбарлана.

### **Хоёр.Эрх бүхий байгууллагын чиг үүрэг**

#### **2.1.Эрх бүхий байгууллагын чиг үүрэг**

2.1.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилтийн удирдлагыг хариуцан ажиллах бөгөөд энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.1.төслийн саналыг энэ журамд зааснаар хүлээн авах, нэгтгэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналтыг хэрэгжүүлэх;

2.1.1.2.төслийн төсвийн эрсдэлийн шинжилгээг хийх, тухайн төслийн санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон улсын төсөвт учруулж болох дарамт, нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах;

2.1.1.3.төслийг үнэлж, эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулах;

2.1.1.4.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаан төслийн нийт саналыг боловсруулах;

2.1.1.5.улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж ажиллах;

2.1.1.6.хууль, журмын шаардлага хангасан төслийн гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг нээх;

2.1.1.7.хууль, журмын шаардлага хангаагүй төслийн санхүүжилтийг олгохгүй байх;

2.1.1.8.энэ журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллага, холбогдох бусад этгээдээс гаргуулж авах;

2.1.1.9.төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төслийн хэрэгжилтийг үнэлэх, үр ашиг, үр дүнг тооцох аргачлал, үнэлгээний тайлангийн загварыг боловсруулж, хэрэгжүүлэх;

2.1.1.10.цахим системийн удирдлагыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах;

2.1.1.11.улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах;

2.1.1.12.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн хэрэгжилттэй танилцах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах.

2.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.2.1.төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх;

2.1.2.2.төслийн саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

2.1.2.3.энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төслийн саналыг улсын төсөвт тусгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.1.2.4.улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

2.1.2.5.энэ журамд заасан аргачлал, заавар, гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах;

2.1.2.6.төслийн хэрэгжилтийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих;

2.1.2.7.улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр тухайн салбарын судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга, мэдээлэл бэлтгэх;

2.1.2.8.улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийг цахим системээр дамжуулан гүйцэтгэх;

2.1.2.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах;

2.1.2.10.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн гүйцэтгэлийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн, үнэн зөв бүрдүүлэх.

2.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагаа, үр дүнг хариуцаж ажиллана.

2.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.1.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд хэрэгжүүлж байгаа төсөл тус бүрт хамаарах гэрээний хуулбарыг (барилга угсралт, их засварын ажлын тухайд үе шатны хуваарь, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан худалдан авах ажиллагааны баримт бичгийн хамт) уг гэрээг байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.1.6.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 2.1.5-д заасан гэрээг цахим системд бүртгэж, хуулбар файлыг оруулсан байна.

2.1.7.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн задаргааг холбогдох шийдвэрийн хамт санхүү,

төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

2.1.8.Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын үе шатуудад холбогдох мэдээлэл, баримт бичгийн иж бүрдлийг цахим системд оруулж, албан бичгээр баталгаажуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд тэдгээрийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангаж ажиллана.

## 2.2.Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх

2.2.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийн хэрэгжүүлэх эрхийг дараах байдлаар шилжүүлнэ:

2.2.1.1.Төсвийн тухай хуулийн 14.4 дахь заалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагчид, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг шилжүүлэх;

2.2.1.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6 дахь заалтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх;

2.2.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төслийг хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулийн 14, 61 дүгээр зүйлд заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлэх.

2.2.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.2.3.Эрх шилжүүлэн авсан этгээд нь тухайн төслийг хэрэгжүүлэхэд энэ журамд заасныг удирдлага болгон ажиллана.

2.2.4.Эрх шилжүүлсэн этгээд нь тухайн төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагналт, үр дүн, гүйцэтгэлд эрх бүхий этгээдийн хувиар хариуцлага хүлээнэ.

## 2.3.Захиалагчийн чиг үүрэг

### 2.3.1.Захиалагч нь дараах этгээд байна:

2.3.1.1.төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төсвийн захирагч;

2.3.1.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2-т заасан этгээд.

### 2.3.2.Захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.2.1.төслийн гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл нэг бүрээр тулган шалгаж, хянан баталгаажуулах;

2.3.2.2.санхүүжилтийн гүйцэтгэлийн баримт бичгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх олгосон шийдвэрийн дагуу төсвийн шууд захирагч, эсхүл санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын гарын үсгээр хянан баталгаажуулж, албан бичгээр болон цахим системээр дамжуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.3.2.3.барилга байгууламж, их засварын ажил, зөвлөх үйлчилгээ, концессын гэрээний эргэн төлөлт зэрэг төслийн гүйцэтгэлийг энэ журамд зааснаар үнэн зөв гаргаж, холбогдох маягтын дагуу ирүүлэх;

2.3.2.4.барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар холбогдох дүрмийн дагуу ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн санхүүжилт хүсэх;

2.3.2.5.барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх;

2.3.2.6.төслийн санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт бичиг, мэдээллүүдийн иж бүрдэл, үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ.

2.3.3.Захиалагч төслийн худалдан авах ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан болохыг баталгаажуулсан тодорхойлолтыг гүйцэтгэлийн баримт бичигт хавсарган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Гурав.Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, тавигдах шаардлага**

#### **3.1.Төсөл, арга хэмжээний төлөвлөлт**

3.1.1.Төслийг төлөвлөх харилцааг энэ журмын 1.2.2-т заасан журам болон аргачлалд зааснаар зохицуулна.

3.1.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төслүүд нь төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон төсөл байх бөгөөд энэ журамд зааснаар төлөвлөнө.

3.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2-т заасан төслийг төсөвт тусгуулах саналыг албан бичгээр болон цахим системээр дамжуулан Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2-т заасан төслийн саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна:

3.1.4.1.бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;

3.1.4.2.Хөгжлийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй нийцэж буй байдал;

3.1.4.3.хэрэгцээ шаардлага, үндэслэл;

3.1.4.4.мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

3.1.4.5.төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;

3.1.4.6.санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл.

3.1.5.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт төслийн төлөвлөгөөний саналыг энэ журмын хавсралт №1-д заасан маягтын дагуу цахим системд мэдээллийг бүрэн оруулж боловсруулна.

3.1.6.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг энэ журамд заасныг баримтлан гүйцэтгээгүй, шаардлагатай баримт бичгийн иж бүрдэл, материал, мэдээллийг албан бичгээр болон цахим системээр ирүүлээгүй тохиолдолд хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгахгүй байх үндэслэл болно.

3.1.7.Төсвийн ерөнхийлөн захирагч болон концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар эргэн төлөлт хийгдэх концессын төслийн санал, тооцоог гаргаж, холбогдох бусад баримт бичгийн хамт хуульд заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар болон албан бичгээр ирүүлнэ.

## 3.2.Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага

3.2.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

3.2.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх дараах шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй:

3.2.2.1.эрх бүхий байгууллагаас газрын болон бусад төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

3.2.2.3.шаардлагатай тохиолдолд төслийн техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх), техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (цаашид “ТЭЗУС” гэх)-г хийлгэсэн байх.





3.2.3.Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөлд дараах шаардлагыг тавина:

3.2.3.1.шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх;

3.2.3.2.төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх;

3.2.3.3.холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

3.2.3.4.тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх.

3.2.4.ТЭЗУС, ТЭЗҮ боловсруулах төсөл болон зөвлөх үйлчилгээний ажил нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, байгууллагын эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байна.

### 3.3.Төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгах

3.3.1.Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 1.2.2.1-д заасан журмыг баримтлан төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална:

3.3.1.1.шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл;

3.3.1.2.их засварын төсөл;

3.3.1.3.шинээр хэрэгжүүлэх төсөл.

3.3.2.Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь нийт төслийн жагсаалтыг энэ журмын 3.1.2-т заасан журам, аргачлалыг үндэслэн боловсруулах ба тухайн жилийн төсвийн хязгаарыг үндэслэн эрэмбийн дагуу төсвийн төсөлд тусгана.

3.3.3.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн хязгаар, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг хянаж, судалсны дагуу төсвийн төсөлд тусгах шийдвэрийг гаргана.

3.3.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийг төсөвт тусгахдаа дараах журмыг баримтална:

3.3.4.1.нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;

3.3.4.2.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

### **Дөрөв.Төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн баримт бичиг**

#### **4.1.Санхүүжилтийн ерөнхий зохицуулалт**

4.1.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төслийн гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актад захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилж, томилсон тухай шийдвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь барилга захиалагчийн хяналт тавих этгээдтэй захиалагчийн хяналтын гэрээ заавал байгуулсан байх бөгөөд гэрээний хуулбарыг тухайн төслийн гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

4.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах үүрэгтэй.



4.1.4. Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төслийн зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.

4.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл төсвийн шууд захирагч нь санхүүжилтийн гүйцэтгэлийг энэ журмын хавсралт №7, №8, №9-д заасан маягтуудын дагуу баталж, санхүүжилт хүссэн албан бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх ба албан бичигт дараах мэдээллийг тусгасан байна:

4.1.5.1. тухайн төслийн төсвийн тухай хуулиар батлагдсан хуулийн дугаар, нэр, төслийн хэрэгжилтийн мэдээлэл, захиалагч хянан баталгаажуулсан тухай мэдээллийг оруулах;

4.1.5.2. гүйцэтгэгч байгууллагад олгох санхүүжилтийн дүнг, гүйцэтгэгчийн дансны дугаар, банкны нэрийн хамт тусгасан байх, энэ нь гэрээнд тусгасан дансны мэдээлэлтэй адил байх;

4.1.5.3. гүйцэтгэгч байгууллагад олгохоос бусад санхүүжилтийн дүнг захиалагчийн дансанд олгохоор захиалагчийн дансны нэр, дугаарын хамт тусгах;

4.1.5.4. эцсийн санхүүжилт олгох тохиолдолд чанарын баталгааны санхүүжилтийн дүнг захиалагч байгууллагын дансанд шилжүүлэхээр тусгах, цахим системд оруулсан татварын мэдээлэлд үндэслэн тухайн гүйцэтгэгч нь татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс татварын өрийг суутган шилжүүлэх талаар тусгах, энэ нь татварын өрийг суутган тооцож санхүүжилтийг шилжүүлэх үндэслэл болно.

4.1.6. Захиалагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын хавсралтад заасан тухайн төсөлд тохирох хяналтын хуудсыг хөтөлж, санхүүгийн баримт болгон гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргана.

4.1.7. Захиалагчаас хянан баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлийн баримт бичиг нь энэ журмын холбогдох хавсралтад заасан хяналтын хуудаст тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал

хариуцсан нэгж ажлын 3 хоногийн дотор тухайн төслийн санхүүжилтийн захиалагч байгууллагын ирүүлсэн албан бичигт дурдсаны дагуу гүйцэтгэгч байгууллагад олгох, захиалагч байгууллагад олгох байдлаар эрхийг нээнэ.

4.1.8.Энэ журам болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хяналтын хуудас бүрэн бүрдсэн тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж санхүүжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт №14-т заасан маягтын дагуу гаргаж, хавсралт №17-ын хамт төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

4.1.9.Энэ журмын 4.1.8-д заасан жагсаалтад тухайн жилийн батлагдсан төсвийн тухай хуулийн хавсралтад тэмдэглэгдсэн хөрөнгө оруулалтын ажлын нэр, дэс дугаар, захиалагч, гүйцэтгэгчийн нэр, гүйцэтгэгч болон захиалагчийн дансны дугаар, санхүүжих мөнгөн дүнг тэмдэглэсэн байна.

4.1.10.Хяналтын хуудас бүрэн бөглөгдөх боломжгүй, санхүүжилтийн баримт бичиг иж бүрдэл дутуу, шаардлага хангахгүй, тэдгээрт тусгагдсан асуудал холбогдох хууль тогтоомжид нийцээгүй бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчаас ирүүлсэн баримт бичгийг ажлын 3 хоногийн дотор цахимаар болон албан бичгээр буцаана.

4.1.11.Эрх шилжүүлсэн төслийн хувьд тухайн шийдвэр нь захиалагчийн холбогдох дансанд санхүүжилтийн эрхийг нээх үндэслэл болно.

4.1.12.Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно:

4.1.12.1.тухайн төсөлд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тусгасан байх;

4.1.12.2.урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт”-ын дагуу гаргана);

4.1.12.3.банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг олгоход урьдчилгаа төлбөрийн банкны баталгааг банканд байршуулсан эсэх баримтыг санхүүжилт хүсэх баримтад хавсаргасан байх;

4.1.12.4.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын улсын төсвийн санхүүжилтээр санхүүжих төслийн урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна.

4.1.13.Төслийн гүйцэтгэлд зөвхөн уг ажилд захиалагчаас гадна захиалагчийг төлөөлж техник хяналт, зохиогчийн хяналт тавьж байгаа болон санхүүжилтийн үйл ажиллагаанд оролцогч эрх бүхий этгээд гарын үсэг зурна.

4.1.14.Төслийн гүйцэтгэгч этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулж, гэрээ байгуулах бөгөөд гэрээтэй холбоотой аливаа зохицуулалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

4.1.15.Төслийн гэрээнд барилга угсралтын дүн, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт зардлыг нэг бүрчлэн тусгахаас гадна тухайн гүйцэтгэгч татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс суутган тооцох тухай заалтыг тусгасан байна.

4.1.16.Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгын үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт нэг бүрчилсэн төсвийн зардлыг тооцно.

4.1.17.Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

4.1.18.Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн энэ журмын хавсралт №16-д заасан маягыг бөглөж олгоно.

4.1.19.Төсвийн орлого бүрдүүлэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс хамаарч тогтоосон хугацаанд хөрөнгө оруулалтын төсөл нь санхүүжилт авч чадаагүй бол энэ нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

4.1.20.Төсвийн орлого бүрдүүлэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс энэ журмын 4.1.7-д заасан хугацаанд төслийг санхүүжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн эрхийг нээхдээ зөвхөн тэдгээрийн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгэгдсэн огнооны дарааллыг баримтална.

4.1.21.Санхүүжилтийн эрх нээснээс хойш ажлын 2 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн асуудал хариуцсан нэгж нь гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгоно.

4.1.22.Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл төсвийн шууд захирагч нь энэ журмын 4.1.5-д заасны дагуу санхүүжилтийн гүйцэтгэлийг цаасаар болон цахимаар баталгаажуулж ирүүлснээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн асуудал хариуцсан нэгж нь захиалагчийн данснаас гүйцэтгэгч байгууллага руу санхүүжилтийг олгох эрх олгогдоно.

4.1.23.Энэ журмын 4.1.22-т зааснаар санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага руу олгосноос гарах аливаа эрсдэл, үр дагаврыг санхүүжилтийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж ирүүлсэн захиалагч байгууллага хүлээнэ.

4.1.24.Энэ журмын 4.1.22-т зааснаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн асуудал хариуцсан нэгж нь санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага руу олгосноор захиалагч байгууллага хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

4.1.25.Энэ журмын 4.1.22 дахь заалттай холбогдуулан гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэхийг гүйцэтгэлийн материалд хавсаргасан байх, мөн энэ журмын хавсралт №17-д заасан “Санхүүжилтийн төлбөрийн хүсэлтийн маяг”-ыг 2 хувь үйлдэж баталгаажуулан ирүүлнэ.

4.1.26.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийх шалтгаан нөхцөл үүссэн тохиолдолд санхүүжилтийн дүнд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг захиалагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төлөвлөгөө батлагдтал түр хугацаагаар зогсоож, шинэчлэгдсэн төлөвлөгөө батлагдсаны дараа шийдвэрлэнэ.

4.1.27.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төслөөс Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутагт эрх шилжин худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах ажлын жагсаалтыг тушаалаар баталж, худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөнд хавсарган төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

4.1.28.Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг даргын төрийн сан дахь хөрөнгө оруулалтын данс төсвийн жилийн эцэст үлдэгдэлгүй байх бөгөөд энэ нь барьцаа хөрөнгийн болон техник хяналтын дансанд хамаарахгүй.

4.1.29.Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

4.1.30.Төслийн эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээ дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маяг”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

4.1.31.Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

4.1.32.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төслийг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно.

4.1.33.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг

хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

4.1.34.Төсвийн орлого бүрдүүлэлтээс хамаарч тогтоосон хугацаанд төсөл нь санхүүжилт авч чадаагүй бол тухайн хугацаагаар төслийн гэрээний хугацааг санхүүжилт орсон өдөр хүртэл хойшлуулан тооцож санхүүжилт гаргана.

4.1.35.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл нь урьдчилсан худалдан авах ажиллагаанд хамаарч буй тохиолдолд гүйцэтгэлийн баримт бичигт уг төслийг баталсан Засгийн газрын тогтоолыг хавсаргаж ирүүлнэ.

4.1.36.Урьдчилгаа төлбөрийн банкны баталгаа болон барилгын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүүжилтийг зогсоож, энэ талаар арга хэмжээ авахуулахаар асуудлыг захиалагч болон холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

#### 4.2.Барилга байгууламжийн ажлын санхүүжилт

4.2.1.Барилга байгууламжийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт нь Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад нийцсэн байна.

4.2.2.Барилга байгууламжийн ажил нь барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг хангасан байна.

4.2.3.Захиалагчийн барилга байгууламжийн ажлын санхүүжилт хүссэн баримт бичгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх олгосны дагуу төсвийн шууд захирагч эсхүл санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын гарын үсгээр хянан баталгаажуулах бөгөөд албан бичиг болон цахим системээр дамжуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.



4.2.4.Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу гаргана.

4.2.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх гүйцэтгэлийн баримт бичгийн хавсралт №7-д заасан “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга угсралтын ажлын санхүүжилтийн хүсэлтийн маягт”-ийн дагуу санхүүжилтийн хүсэлтийг баталгаажуулж ирүүлнэ.

4.2.6.Захиалагч нь төслийн эцсийн санхүүжилтийн хүсэлтийг ирүүлэхдээ барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

4.2.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж хянан баталгаажуулж, холбогдох баримт бичгийг энэ журмын хавсралт №2, №3 дахь хяналтын хуудаст тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг дараах баримт бичгийг үндэслэн санхүүжүүлнэ:

4.2.7.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан бичиг, үнэлгээний хорооны шийдвэр;

4.2.7.2.захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь (Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Гэрээний маягт”-ын дагуу гэрээг байгуулна);

4.2.7.3.эрх шилжүүлсэн тохиолдолд холбогдох шийдвэрийн хуулбар;

4.2.7.4.тендер шалгаруулалтад шалгарч гэрээ байгуулсан этгээдийн барилга угсралт, их засварын ажлын төлөвлөгөө, түүнийг төсөвт өртөгт эзлэх дүнгээр тодорхойлсон барилгын ажлын үе шатны хуваарь (энэ журмын хавсралт №9-д заасан маягтын дагуу гаргана);

4.2.7.5.гүйцэтгэлийн баталгаа (Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн баталгааны маягт”-ын дагуу гаргана);



4.2.7.6.захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл (энэ журмын хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана);

4.2.7.7.барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг нотлох гэрэл зураг (10-аас ихгүй байх);

4.2.7.8.магадалшгүй ажлын зардлын барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон акт, хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл;

4.2.7.9.зураг төсөл боловсруулах гэрээ, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналтын тухайн төсөл дээр байгуулсан гэрээний хуулбар, хийсэн ажлын тайлан;

4.2.7.10.барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын актыг үйлдэж, комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана;

4.2.7.11.захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын ил далд ажлын акт;

4.2.7.12.төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудаст тендер шалгаруулалтын мэдээллийг бүрэн оруулсан байх.

4.2.8.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах төслийн санхүүжилтийг хавсралт №3-т заасан хяналтын хуудсыг хөтөлж олгоно.

4.2.9.Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацааг Барилгын тухай хуулийн 14.6-д, авто замын байгууламжийн тухайд Авто замын тухай хуулийн 28.4-т заасныг баримтлах бөгөөд баталгаат хугацаанд байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна.

4.3.Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилт

4.3.1.Захиалагч их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана.

4.3.2.Захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

4.3.3.Их засварын ажлыг хийж дуусаад комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана.

4.3.4.Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулан тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, хавсралт №11-д заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

4.3.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь тоног төхөөрөмжийн санхүүжилтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн хавсралт №6-д заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.

4.3.6.Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилтэд энэ журмын 4.1 болон 4.2 дугаар зүйлд заасан холбогдох зохицуулалт мөн адил үйлчилнэ.

#### 4.4.Зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилт

4.4.1.Зөвлөх үйлчилгээний ажлыг холбогдох хуульд зааснаар тодорхойлох бөгөөд зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ТЭЗУС болон ТЭЗҮ-д дараах ажлууд хамаарна:

4.4.1.1.ТЭЗУС-ны хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, зорилт, хүрэх үр дүн, нийгэм, эдийн засгийн үр нөлөө, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх

арга замыг урьдчилсан байдлаар тоймлон судлах, хэрэгжих боломжийг тоймлон тогтоох судалгааны ажил болон холбогдох тайланг боловсруулах;

4.4.1.2.ТЭЗҮ боловсруулах ажилд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг эрэлт хэрэгцээ, нөөц боломж, техник-технологи, эдийн засаг, хууль, эрх зүй, үйл ажиллагаа болон цаг хугацааны хувьд хэрэгжих боломжийг судлан тогтоох, тухайн төслийн үр дүн болон үр ашгийг тодорхойлох, гарч болзошгүй эрсдэл, зардлуудыг тодорхойлох судалгааны ажил болон холбогдох тайланг бэлтгэх.

4.4.2.Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх шилжүүлснээр хэрэгжүүлж буй төслийн ажилд шаардлагатай зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэж, зөвлөхийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар сонгон шалгаруулах ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг сонгож, гэрээ байгуулна.

4.4.3.Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар нь түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

4.4.4.Зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна.

4.4.5.Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дагуу ажил гүйцэтгэх гэрээнд тусгаж ажиллана.

4.4.6.Зөвлөх үйлчилгээний зардлыг олгох санхүүжилтийн баримт бичигт гэрээний эх хувь, зохиогчийн хяналтын зардал өгөх тохиолдолд зохиогчийн хяналтын гэрээ, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөв тус бүрийн эх хувь, эсхүл хуулбар, хүлээн авсан акт заавал хавсаргана.

4.4.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн хавсралт №5-д заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.

4.5.Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт

4.5.1.Концессын гэрээний эргэн төлөлтийг төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр олгох асуудлыг концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төслийн санхүүжилттэй холбогдон гарсан хууль, эрх зүйн акт, Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох байгууллагын шийдвэрт үндэслэн санхүүжүүлнэ.

4.5.2.Концессын гэрээний дагуу гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний төлбөрийг гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэхгүйгээр санхүүжүүлэх бөгөөд бодит гүйцэтгэл нь гэрээний үнийн дүнгээс бага бол эргэн төлөлтийг бодит гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

4.5.3.Төсвийн ерөнхийлөн захирагч болон концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь концессын эргэн төлөлттэй холбогдолтой санхүүгийн болон бусад холбогдох баримт бичгийн үнэн зөв эсэхийг хянан баталгаажуулж, тухайн санхүүжилтийн дүнг тусгасан албан бичгээр болон цахим системд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

4.5.4.Концессын гэрээний эргэн төлөлтийн санхүүжилтийг шийдвэрлэхэд дор дурдсан баримт бичгийн иж бүрдлийг хангасан байна:

4.5.4.1.Концессын тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-аар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай холбогдох байгууллагын шийдвэр дүгнэлт, хурлын тэмдэглэл;

4.5.4.2.захиалагчийн зүгээс концессын гэрээнд заасан уг гэрээг хүчин төгөлдөрт тооцох нөхцөлүүд хангагдсан эсэх талаарх дүгнэлт;

4.5.4.3.концессын гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан гэрээний талууд гэрээг эцэслэн дүгнэсэн дүгнэлт;

4.5.4.4.концессын гэрээнд өөрчлөлт оруулсан бол гэрээний нэмэлт, өөрчлөлт болон эргэн төлөлтийн хуваарийг дараа онуудад шилжих дүнг төгрөгөөр илэрхийлсэн байх;

4.5.4.5.санхүүжилттэй холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн дагуу хөндлөнгийн байгууллагын дүгнэлт, зөвлөмж



болон тухайн төсөлтэй холбогдон гарсан дүгнэлт, зөвлөмжийн дагуу шаардлагатай баримт бичиг;

4.5.4.6.Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын хуулбар;

4.5.4.7.захиалагч болон концесс эзэмшигчийн хооронд байгуулсан концессын гэрээний эх хувь, эсвэл захиалагч байгууллага хянаж, нотариатаар баталгаажуулсан концессын гэрээний хуулбар хувь байж болно;

4.5.4.8.захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл, гэрээнд багтсан санхүүгийн бусад зардал нэг бүрээр концесс эзэмшигчтэй тооцоо нийлсэн акт;

4.5.4.9.барилга, байгууламж, засварын ажил, тоног төхөөрөмжийн гэрэл зураг;

4.5.4.10.ТЭЗҮ, зураг төсөл болон төсөв, техник хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээний хуулбар, захиалагчийн хяналтын гэрээ дүгнэсэн дүгнэлт;

4.5.4.11.барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт;

4.5.4.12.төсвийн шууд захирагчийн хянан баталгаажуулсан санхүүжилтийн дүнтэй албан бичиг;

4.5.4.13.магадалшгүй ажлын акт, төсөв, гүйцэтгэл, баримтжуулсан фото зураг, хурлын тэмдэглэл.

4.5.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь концессын гэрээний эргэн төлөлтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн хавсралт №4-т заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.

4.5.6.Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төслийг холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэж, санхүүгийн тайланд тусгана.

4.5.7.Энэ журмын 4.5.4-т заасан баримт бичгийн бүрдлийн үнэн зөв эсэхийг захиалагч буюу төсвийн захирагч бүрэн хариуцна.

### **Тав.Ил тод байдал, хяналт, тайлагналт, үр дүн**

#### **5.1.Санхүүжилтийн ил тод байдал**

5.1.1.Төслийн санхүүжилтийг олгохтой холбоотой баримт баримт бичгүүдийг энэ журамд дурдсанаар бүрдүүлж, албан бичгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээс гадна цахим системийн “Санхүүжилтийн гүйцэтгэл” гэсэн цэсэд оруулж, давхар баталгаажуулж олон нийтэд мэдээлнэ.

5.1.2.Цахим системд нэвтрэх баталгаажуулах хэрэглэгчийн эрхийг санхүүжилтийн үйл ажиллагаанд оролцогч болох гүйцэтгэгч, захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллага, захиалагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалт болон төрийн сангийн асуудал хариуцсан нэгж зэрэг байгууллагад олгоно.

5.1.3.Гүйцэтгэгч байгууллагын цахим системд нэвтрэх эрхийг захиалагч байгууллага, бусад хэрэглэгчийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж олгоно.

5.1.4.Тухайн ажлыг гүйцэтгэсэн гүйцэтгэгч нь гэрээт ажлын санхүүжилтийг авах хүсэлтээ тухай бүр албан бичгээр болон цахим системд холбогдох мэдээллийг оруулж, цахим системээс хэвлэгдэх хавсралт №15-д заасан маягтыг гүйцэтгэлийн баримт бичигт хавсарган дараагийн шатны байгууллагад илгээж, хүргүүлнэ.

5.1.5.Гэрээний дагуу захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллага нь гүйцэтгэгчийн баримт бичгийг хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор хянан баталгаажуулж, гэрээ байгуулсан этгээд буюу захиалагчид албан бичгээр хүргүүлэх бөгөөд цахим системд энэ талаар баталгаажуулна.

5.1.6.Захиалагч нь гүйцэтгэлийг ажлын 2 хоногийн дотор хянан баталгаажуулж, санхүүжилтийн хүсэлтийг албан бичгээр болон цахим системд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



5.1.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь санхүүжилтийн хүсэлтийг хүлээн авч, тухайн ажлын санхүүжилт олгох үндэслэл, нөхцөлийг хянах бөгөөд санхүүжилтийн эрхийг нээсэн тохиолдолд цахим системд баталгаажуулан тус байгууллагын төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

5.1.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн асуудал хариуцсан нэгж захиалагчийн төрийн санд шилжих процессыг цахим системд баталгаажуулна.

5.1.9.Санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг цахим системд оруулж, баталгаажуулаагүй тохиолдолд санхүүжилтийг олгох боломжгүй болно.

5.1.10.Нууцын тухай хууль тогтоомж, талуудын гэрээнд зааснаас бусад тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагаа, мэдээлэл болон бүртгэл, тайлагналт нь ил тод байна.

5.1.11.Цахим системийн мэдээллийг олон нийтэд зориулсан [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) цахим хуудаст байршуулах бөгөөд андройд болон iOS үйлдлийн системд ажиллах боломжтой “төсвийн хөрөнгө оруулалт” болон “publicinvestment” нэр бүхий аппликейшнаар дамжуулан мэдээллийг нийтэд хүргэнэ.

5.1.12.Санхүүжилтийн хүсэлтийг албан бичгээр ирүүлэхээс гадна цахим системд баталгаажуулах шаардлагатай бөгөөд холбогдох байгууллагууд цахим системд илгээгээгүй тохиолдолд санхүүжилтийг буцаах үндэслэл болно.

5.1.13.Санхүүжилтийн үйл ажиллагааг цахимд системд оруулахдаа гарын авлагыг мөрдлөг болгож ашиглана.

## 5.2.Хяналт

5.2.1.Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.



5.2.2.Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана.

5.2.3.Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

5.2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээний ажилд шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна. Уг ажилд хяналт, шалгалтын мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж болно.

5.2.5.Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.

5.2.6.Захиалагч байгууллага төсвийн хөрөнгөөр хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг ажиллуулах бөгөөд хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани нь хяналт хийсэн тэмдэглэлийг тухай бүр үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивд хадгалуулна.

5.2.7.Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудалд төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудаар хөндлөнгийн хяналт тавиулж болно.

5.2.8.Орон нутагт хийгдэж байгаа төсвийн хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой асуудлаар иргэд гомдол гаргавал нутгийн

захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, боломжгүй бол асуудлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, хяналт шалгалтын мэргэжлийн байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ.

### 5.3.Тайлагналт, үр дүн

5.3.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажил тус бүрийн санхүүжилтийн дүн, явц байдлыг энэ журмын хавсралт №8-д заасан маягтын дагуу тогтмол гаргаж, төсвийн ил тод мэдээллийн сайтад байршуулна.

5.3.2.Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг цахим системд тухай бүр журамд зааснаар тусгах бөгөөд тухайн байгууллагын мэдээллийн сүлжээнд шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд санхүүжилт хийгдсэн мэдээллийг тухай бүр шинэчилж байна.

5.3.3.Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.

5.3.4.Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

5.3.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3.6.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайланг сар бүр энэ журмын хавсралт №10-т заасан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.3.7.Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан боловч худалдан авах ажиллагаа нь орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй

хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь сар бүр энэ журмын хавсралт №10-т заасан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

5.3.8.Төсвийн ерөнхийлөн захирагч нь ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг дараа оны 4 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын хавсралт №13-т заасан маягтын дагуу гаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.3.9.Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, төслийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн холбогдолтой бүх баримт бичиг, комиссын актуудыг хариуцсан албан тушаалтан Архивын тухай хуулийн дагуу архивлаж хадгална.

5.3.10.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл тус бүрийн талаар дараах мэдээллийг агуулсан тайланг тогтмол гаргах бөгөөд санхүүгийн дүн тооцоог өөрийн байгууллагын санхүүгийн жилийн тайланд тусгаж тайлагнана:

5.3.10.1.төслийн танилцуулга;

5.3.10.2.гэрээнд заасан урт хугацаанд бэлэн мөнгөний урсгал, санхүүгийн нөлөө үзүүлж болох гэрээний гол нөхцөлүүд;

5.3.10.3.гэрээний зүйлийг ашиглах эрх, үйлчилгээг үзүүлэх үүрэг, хөдлөх, болон үл хөдлөх хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөнд шилжүүлэх, аливаа хөрөнгийг хүлээн авах, шилжүүлэх, гэрээг сунгах, цуцлах заалт, бусад үндсэн ашиглалт болон засвар үйлчилгээний талаарх мэдээлэл.

5.3.11.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийн үр дүнг дүгнэж, тухайн барилга байгууламж ашиглалтад орсноос хойш 2-3 жилийн дараа төслийн хүчин чадлын ашиглалтыг шалгаж, энэ талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

## **Зургаа.Бусад зүйл**

### **6.1.Бусад зүйл**

6.1.1.Энэ журмыг хэрэгжүүлэх албан хаагч нь чиг үүргээ төсвийн сахилга бат, мэргэжлийн ёс зүйг баримтлан, хууль ёсны дагуу, ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус, бие даан гүйцэтгэх ба тухайн этгээдийн хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

6.1.2.Төслийн гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.

6.1.3.Давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд баримт бичиг хүлээн авах хугацааг хойшлуулж төсвийн ерөнхийлөн захирагчид энэ тухай мэдэгдэнэ.

6.1.4.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мэдээллийг [www.iltod.mof.gov.mn](http://www.iltod.mof.gov.mn), <https://mof.gov.mn>, [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) цахим хуудаст тухай бүр мэдээлнэ.

6.1.5.Энэ журмын 5.3.9-д зааснаар баримт бичгийг архивд өгөөгүй тохиолдолд холбогдох хариуцлагыг тухайн асуудал хариуцсан албан тушаалтан болон түүний удирдлага хүлээнэ.

6.1.6.Энэ журамд заасныг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.1.7.Гэрээний талууд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.



Хавсралт №1

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭРЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН МАЯГТ

№	Аймаг, нийслэл	Сум, Дүүрэг	ТӨЗ-ийн оноо	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэмжих нэгж	Хүчин чадал	Төслийн төрөл	Төслийн ангилал	Хугацаа		Төслийн төсөвт өртөг онуудад /сая төг/
									Эхлэх	Дуусах	
1.											

Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн санхүүжсэн дүн	Санхүүжилт /сая төг/		Нийт авсан санхүүжилт /сая төг/	Байгууллагын санал		Төсвийн ерөнхийлөн захиралч
	Нийт авсан санхүүжилт /сая төг/	Нийт авсан санхүүжилт /сая төг/		Төсвийн төсөлд тусгах өртөг /сая төг/	Төсвийн төсөлд тусгах санхүүжих дүн /сая төг/	

Төслийн шинжилгээ хийгдсэн эсэх	Батлагдсан зураг төсөл болон төсөв	Газрын зөвшөөрөл	Техникийн нөхцөл	Оноо өгөгдсөн эсэх	Ахлын явц хувь /шилжих төслийн хувьд/	Гүйцэтгэгч компани /шилжих төслийн хувьд/	Хуудалдан авах ажиллагааны мэдээлэл /Шилжих төслийн хувьд/	
							Төндөр зарласан огноо	Төндөр зарлагүй гэрээ байгуулаагүй

\*-Жил бүр Төсвийн төсөл боловсруулах удирдамжийн хамт Төсвийн ерөнхийлөн захиралчид хүргүүлэх маягт, үүний дагуу албан бичгээр болон дээрх хүснэгтийн мэдээллийг цахим системд оруулна.



Хавсралт №2

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүчин чадал, байршил.....
Гэрээний дугаар.....
Гүйцэтгэлийн дугаар..... Гүйцэтгэгчийн нэр .....
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

Table with 4 columns: №, Шалгуур үзүүлэлт, шаардлага, Тийм, Үгүй. It contains 18 rows of criteria for evaluating the tender process.

Тайлбар:
"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэлээ хийхгүй.

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БУХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН
САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ
ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН
ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг/

огноо



Хавсралт №3

ХУДАЛДАН АВАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН  
САНХҮҮЖИЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүчин чадал, байршил.....  
Гэрээний дугаар.....  
Гүйцэтгэлийн дугаар..... Гүйцэтгэгчийн нэр .....

Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

№	Шалгуур үзүүлэлт, шаардлага	Тийм	Үгүй
1.	Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томъёотой тохирч байгаа эсэх		
2.	Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх <i>/Нийт төсөвт өртөг нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шүүд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно!</i>		
3.	Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх		
4.	Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх		
5.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд баталгаажуулсан эсэх		
6.	Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт <i>/Яамдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЗД-ын гарын үсгэтэй байх/</i> ирүүлсэн байх		
7.	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнэ эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтрээгүй эсэх		
8.	Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх		
9.	Санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх		
10.	Худалдан авах үнийг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр үнэлгээ хийлгэсэн байх		
11.	Барилгын чанар, стандарт нь ашиглалтын шаардлага хангаж байгаа талаар захиалагч болон ашиглагч байгууллагын дүгнэлттэй байх		
12.	Үл хөдлөх хөрөнгийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээг захиалагч эсхүл ашиглагч байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байх		
13.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх		
14.	Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх		
15.	Барилга угсралтын болон их засварын ажил нь хувийн, эсхүл өмчийн бусад хэлбэрийн этгээдийн өмчлөлийн зүйлд хийгдээгүй байх		
16.	Тендэрт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх		

Тайлбар:

"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.  
ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН  
САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ  
ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/  
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ  
БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг/

огноо

Хавсралт №4

**КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Төслийн нэр, хүчин чадал, байршил.....

Гэрээний дугаар.....

Гүйцэтгэлийн дугаар.....

Гүйцэтгэгчийн нэр .....

Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

№	Шалгуур үзүүлэлт, шаардлага	Тийм	Үгүй
1.	Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан эсэх		
2.	Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томъёотой тохирч байгаа эсэх		
3.	Концесс олгох уралдаант шалгаруулалтын журмаар хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх <i>/Концессын тухай хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/</i>		
4.	Гэрээ байгуулах эрх олгосон Засгийн газрын тогтоолын хуулбар		
5.	Концессын гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдсэн эсэх		
6.	Энэ журмын 13.4-т тусгагдсан баримт бичгийг бүрэн ирүүлсэн эсэх		
7.	Ажлын гүйцэтгэл болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх болон санхүүжих дүнг тусгасан эсэх		
8.	Хөндлөнгийн аудитын дүгнэлттэй эсэх		
9.	Гэрээ дүгнэсэн протокол, дүгнэлттэй эсэх		
10.	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх		
11.	Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн барилга байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгах тухай баримт бичигтэй эсэх		
12.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн улсын комиссын акттай эсэх		

**Тайлбар:**

“Тийм/Үгүй” гэсэн баганад “Тийм”, эсхүл “Үгүй” гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.

**ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН  
САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ**
**ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/**
**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН**
**ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг/**

огноо





Хавсралт №5

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүчин чадал, байршил.....  
Гэрээний дугаар..... Гүйцэтгэчийн нэр .....  
Гүйцэтгэлийн дугаар..... Гүйцэтгэчийн нэр .....  
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

№	Шалгуур үзүүлэлт, шаардлага	Тийм	Үгүй
1.	Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томъёотой тохирч байгаа эсэх		
2.	Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх <i>Инийг төсөвт өртөг нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно!</i>		
3.	Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх		
4.	Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх		
5.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд баталгаажуулсан эсэх		
6.	Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт /ямдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЭД-ын гарын үсэгтэй байх/ ирүүлсэн байх		
7.	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнэ эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтрээгүй эсэх		
8.	Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх		
9.	Санхүүжилт авах тохиолдолд энэ журмын 12 дугаар зүйлд тусгагдсан баримт бичгийг бүрэн ирүүлсэн байна		
10.	Ажлын гүйцэтгэл болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх		
11.	Санхүүжүүлэх дүн нь сар, улирлын батлагдсан хуваарийн өссөн дүнгээс хэтрэхгүй эсэх		
12.	Ажлын гүйцэтгэл болон урьдчилгаа төлбөр, гүйцэтгэлийн баталгаанууд батлагдсан маягтын дагуу гаргагдсан эсэх		
13.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх		
14.	Зөвлөх үйлчилгээний нийт өртөг Төсвийн тухай хуулийн 29.7-д зааснаас бусад тохиолдлоор өсөн нэмэгдээгүй байх		
15.	Зөвлөх үйлчилгээний шууд зардлын дүн нь гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг мөнгөн дүнгээр илэрхийлсэн хувь хэмжээтэй тохирсон, эсхүл ихгүй байх		
16.	Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх		
17.	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх		

**Тайлбар:**  
"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН  
САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ  
ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН  
ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг/

огноо



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүчин чадал, байршил.....

Гэрээний дугаар.....

Гүйцэтгэлийн дугаар.....

Гүйцэтгэгчийн нэр .....

Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

№	Шалгуур үзүүлэлт, шаардлага	Тийм	Үгүй
1.	Төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томъёотой тохирч байгаа эсэх		
2.	Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх /Нийт төсөвт өртөг нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/		
3.	Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх		
4.	Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх		
5.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд баталгаажуулсан эсэх		
6.	Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт /яамдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЗД-ын гарын үсэгтэй байх/ ирүүлсэн байх		
7.	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнэ эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтэрэгүй эсэх		
8.	Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх		
9.	Санхүүжилт авах тохиолдолд энэ журмын 11 дүгээр зүйлд тусгагдсан баримт бичгийг бүрэн ирүүлсэн байна		
10.	Тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх		
11.	Санхүүжүүлэх дүн нь сар, улирлын батлагдсан хуваарийн өссөн дүнгээс хэтрэхгүй эсэх		
12.	Тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон урьдчилгаа төлбөр, гүйцэтгэлийн баталгаанууд батлагдсан маягтын дагуу гаргагдсан эсэх		
13.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх		
14.	Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх		
15.	Тоног төхөөрөмж худалдан авалт нь хувийн, эсхүл өмчийн бусад хэлбэрийн этгээдийн өмчлөлийн зүйлд хийгдээгүй байх, төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэгдэх боломжтой эсэх		
16.	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх		

Тайлбар:

"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэээ хийхгүй.

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИГДЭХ АЖЛЫН ЖАГС ААЛТАД ТУСГАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БҮЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг/

огноо



Хавсралт №7

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН  
САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТ

БАТЛАВ:  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ЭСХҮЛ  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Тамга  
Гарын үсэг  
Нэр

Санхүүжилтийн хүсэлт № ...

Гүйцэтгэчийн нэр

Он сар өдөр

/пөрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Тухайн онд батлагдсан санхүүжилт	Гэрээний дугаар	Нийт гүйцэтгэл	Нийт санхүүжилт	Өмнөх санхүүжилт	Одоо санхүүжих	Үлдэгдэл санхүүжилт
	Төсөл, арга хэмжээний нэр/ барилга угсралтын ажлын гүйцэтгэл .....								
	Урьдчилгаа санхүүжилт								
	Урьдчилгааны эргэн төлөлт								
	Төсвөөс давсан гүйцэтгэл								
	Санхүүжилтийн эрх нээлтэх нийт дүн								
	Захиалагчийн хяналтын зардал								
	Зохиогчийн хяналтын зардал								
	Норм нормативын сан								
	Барьцаа								
	Гүйцэтгэгчид төлөх дүн								

Хянасан:

Холбогдох газрын дарга  
Холбогдох хэлтсийн дарга

Гарын үсэг  
Гарын үсэг  
Нэр  
Нэр

Боловруулсан:

Холбогдох мэрэжлгэн

Гарын үсэг  
Нэр



Хавсралт №8

БАТЛАВ: Захиалагч...../Гарын үсэг, огноо/

*/Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл төсвийн шууд захирагч/*

Захиалагч:

Гүйцэтгэгч:

(байгууллагын нэр, тамга/ тэмдэг)

(байгууллагын нэр тамга/ тэмдэг)

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ № ....

1. Барилга байгууламжийн нэр, байршил: .....
2. Хүчин чадал: .....
3. Гэрээний дугаар: .....
4. Эхлэх ба дуусах хугацаа: .....
5. Гүйцэтгэл гаргасан хугацаа: .....

(Төгрөгөөр)

№	Зардлын нэр, төрөл	Төсөвт өртөг	Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл	Урьд авсан санхүүжилт	Тайлант үеийн гүйцэтгэл	Хянасан гүйцэтгэл	Зардлын төсөвт өртөгт эзлэх хувь	Үлдэгдэл санхүүжилт
1.	Ажиллах хүчний зардал							
2.	Материалын зардал							
3.	Машин, механизмын зардал							
4.	Тээврийн зардал							
5.	Шууд зардлын дүн							
6.	Нэмэгдэл зардал							
6.	Ашиг							
	Барилга угсралтын ажлын дүн							
7.	НӨАТ							
8.	Нормчлолын сан							
	Нийт дүн							
9.	Техник хяналтын зардал							
10.	Зураг төслийн үнэ							
11.	Зохиогчийн хяналтын зардал							
12.	Барилгад угсрагддаг тоног төхөөрөмжийн зардал							
13.	Магадалшгүй ажлын зардал							
	БҮГД ДҮН							
	Бодит ажлын явц (хувиар)							

Гүйцэтгэлийг хүлээн авч хянасан:

Гүйцэтгэл гаргаж, хүлээлгэн өгсөн:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

/ТЕЗ-ийн томилсон албан тушаалтнууд байна. Жишээлбэл:

Санхүү, хөрөнгө оруулалтын газар/  
хэлтсийн дарга.....  
Албаны дарга .....  
Хяналтын инженер .....  
Нягтлан бодогч .....

Захирал .....  
Ерөнхий инженер.....  
Ер. Ня-бо .....



Хавсралт №9

БАТЛАВ: Захиалагч...../Гарын үсэг, огноо/  
/Төсвийн шууд захирагч, эсхүл ТЕЗ-ийн томилсон албан тушаалтан/

БАТЛАВ: Гүйцэтгэгч...../Гарын үсэг, огноо/

..... АЖЛЫН БАРИЛГА УГСРАЛТИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ, ХУАНЛИЙН ХОНОГООР  
/Төсвийн хөрөнгөө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил, гэрээний дугаарыг бичнэ/

№	Гүйцэтгэх ажлын нэр төрөл	Сар			...-р сар			...-р сар			...-р сар			Дүн
		10 хоног	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	
1.	Төл. Гүйц.													
2.	Төл. Гүйц.													
3.	Төл. Гүйц.													
4.	Төл. Гүйц.													
5.	Төл. Гүйц.													
6.	Төл. Гүйц.													
7.	Төл. Гүйц.													
8.	Төл. Гүйц.													
9.	Төл. Гүйц.													
	БҮГД ДҮН /сая төг/													

Хянасан:

Захиалагч...../ТЕЗ-ийн томилсон албан тушаалтны гарын үсэг, тамга/гэмдэг, огноо/  
Гүйцэтгэгч...../Захирал, талбайн инженер, нягтлан бодогч, гарын үсэг, тамга/гэмдэг /

Хавсралт №10

БАТЛАВ: ...../гарын үсэг, огноо/  
/Төсвийн шууд захирагч, эсхүл ТЕЗ-ийн томилсон албан тушаалтан/

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БАРИГДАЖ БҮЙ БАРИЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,  
САНХҮҮЖИЛТИЙН .....-Р САРЫН МЭДЭЭ

202... оны .....сарын .....-ны өдөр

№	Барилга байгууламж, их засварын ажлын нэр, хүчин чадлал, байршил	Эхлэх дуусах	Төсөвт өртөг	202... онд санхүүжих	Санхүүжилт /сая төг/	Ажлын гүйцэтгэл /ажил тус бүрээр бодит гүйцэтгэл, хувийн бичнэ/	1.Төндөр зарласан огноо 2. Гэрээ байгуулсан огноо	Төндөрт шалгарсан гүйцэтгэгч
1.								
2.								
3.								

Хянасан:

..... Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга

/гарын үсэг, тамга/гэмдэг/

Боловсруулсан:

..... Мөргөжилтэн /гарын үсэг/





ГЭРЭЭ ДҮГНЭХ МАЯГТ

Он сар өдөр

Гэрээний нэр:			
Гэрээний дугаар:			
Захиалагч байгууллага:			
Гүйцэтгэгч байгууллага:			
Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа:			
Гэрээгээр ажил дуусгах хугацаа:			
Гэрээний дүн:			
Урьд санхүүжсэн дүн:			
Нийт үлдэгдэл:			
Батлагдсан гүйцэтгэлийн дүн: ..... төгрөг	Санхүүжилтийн дүн: ..... төгрөг		
Үүнээс: БУА	Үүнээс олгогдсон:		
Техник хяналт:			
Зураг төсөл:			
Чанарын баталгаат хугацаанд байршуулсан мөнгөн дүн /төгрөгөө/			
Гүйцэтгэгчээс ажил дууссан тухай мэдэгдэл ирүүлсэн өдөр:	..... оны ..... сарын ..... өдөр Дугаар: .....		
Комиссын актын дугаар:	..... оны ..... сарын ..... өдөр Дугаар: .....		

Гэрээний биелэлт, шийдвэрлэлт:

Гэрээний биелэлт:	Жишээ нь: Ажил бүрэн дууссан. Комисс комиссын акт ..... оны .. дугаар сарын ...-ны өдрийн ..... дугаартай баталгаажсан.
Шийдвэр:	Жишээ нь: Иймд алданги тооцохгүйгээр барьцаа хөрөнгө .... хувь ..... төгрөгийг үлдээж үлдэгдэл санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв.

**ЖИЧ:** Гэрээ хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд дэлгэрэнгүй хурлын тэмдэглэлийг доорхи заалтын дагуу хөтөлж заавал хавсаргаасан байх.

Гэрээ дүгнэсэн:

<u>ЗАХИАЛАГЧ:</u> ..... /...../	<u>ГҮЙЦЭТГЭГЧ:</u> "....." ХХК-ний захирал: /..... /
..... /...../	
хариуцсан мэргэжилтэн /...../	

Тэмдэглэлтэй танилцсан:

Захиалагч талаас /дарга/: /..... /	Захиалагч талаас , санхүү: /..... /
---------------------------------------	--





Хавсралт №13

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ӨМНӨХ ОНД АШИГЛАЛТАД ОРСОН  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХ ХҮСНЭГТЭН МЭДЭЭ

БАТЛАВ: ...../гарын үсэг, тамга/тэмдэг, огноо/

/Төсвийн шууд захирагч, эсхүл ТЕЗ-ийн томилсон албан тушаалтан/

АШИГЛАЛТАД ОРСОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭ

/сая төг/

№	Барилга байгууламжийн нэр, байршил	Барилга байгууламжийн огноо		Ашиглалтад орсон		Захиалагч байгууллага	Ашиглагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага
		Эхэлсэн	Дууссан	Хүчин чадал	Хөрөнгийн дүн			
1.								
2.								
3.								
НИЙТ ДҮН								

Хянасан:

Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга ...../гарын үсэг, тамга/тэмдэг/

Мэргэжилтэн ..... /гарын үсэг/

Мэдээ гаргасан:

Захиалагч байгууллагын дарга ..... /гарын үсэг, тамга/тэмдэг/

Мэргэжилтэн ..... /гарын үсэг/

Хавсралт №14

САНХҮҮ, ТӨСВИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН НЭГЖЭЭС ТӨРИЙН САНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГЖИД САНХҮҮЖИЛТИЙН  
ЭРХ НЭЭЖ ХҮРГҮҮЛЭХ МАЯГТ

№	ID	Дугаар	Захиалагч	Төсөл арга хэмжээний нэр	Захиалагч, Гүйцэтгэгч	Банк Данс	Мөнгөн дүн (төг)	Мэргэжилтэн	Гарын үсэг
1									

Хяналтын хуудсанд тусгагдсан бүх шалгуур үзүүлэлт хангагдсаныг үндэслэн санхүүжих ажлын жагсаалтад тусгахыг зөвшөөрсөн

Төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгжийн дарга ..... /нэр, гарын үсэг/



Хавсралт №15

Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем

**САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТ №1**



Хуулийн дугаар: .....

Төсөл, арга хэмжээний нэр: .....

Гэрээний дугаар: .....

Гүйцэтгэгч: .....

Ажлын явц: .....%

Хүсэлтийн дүн: ..... сая төгрөг



[publicinvestment.gov.mn](http://publicinvestment.gov.mn)

Хэвлэсэн огноо:



Барилга, объектын нэр \_\_\_\_\_

**ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН АКТ № .....**

1. Гэрээний дугаар \_\_\_\_\_
2. Гүйцэтгэл гаргасан \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр
3. Гэрээ эхлэх, дуусах хугацаа \_\_\_\_\_

(төгрөг)

№	Зардлын ангилал	Төсөвт өртөг	Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл	Урьд авсан санхүүжилт /өссөн дүн/	Тайлангийн үеийн гүйцэтгэл	ХЯНАСАН
1.	Ажлын хөлс					
2.	Материаллаг зардал					
3.	Унаа/замын зардал					
4.	Албан томилолт					
	Дүн					
5.	Удирдлагын зардал					
6.	Ашиг					
	Дүн					
7.	НӨАТ					
	Дүн					
8.	Хэмжилт, шалгалт, лабораторийн зардал					
	Дүн					
9.	Нэмэлт ажил					
	Нийт дүн					

ГҮЙЦЭТГЭЛИЙГ:

Хянасан:

Гаргасан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

/ТӨЗ-ийн томилсон албан тушаалтнууд байна.  
Жишээлбэл:

Санхүү, хөрөнгө оруулалтын газар/  
хэлтсийн дарга .....  
Албаны дарга .....  
Хяналтын инженер .....

Захирал .....  
Багийн ахлагч .....  
Инженерүүд /БД, ББ, ХАС, ЦБУ, ДГ, ХД/  
.....  
Нягтлан бодогч .....

Нягтлан бодогч .....  
Мэргэжилтэн .....



Хавсралт №17

**“Санхүүжилтийн төлбөрийн хүсэлтийн маягт”**

1. Төсөл, арга хэмжээний нэр \_\_\_\_\_
3. Гэрээний дугаар \_\_\_\_\_
4. Гүйцэтгэл гаргасан \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр
3. Гэрээ эхлэх, дуусах хугацаа \_\_\_\_\_

(төгрөг)

Байгууллагын нэр:				Дансны дугаар	Дүн /тоогоор/
Регистрийн дугаар:					
№	Хүлээн авагчийн нэр	Регистрийн дугаар	Хүлээн авагчийн банк	Хүлээн авагчийн дансны дугаар	Нийт дүн /тоогоор/
1.					
2.					
3.					
...					
Мөнгөн дүн үсгээр :					
Гүйлгээний утга			Ангилал		Нийт дүн /тоогоор/
			Хөтөлбөр Зориулалт Эдийн засгийн ангилал		
Хяналтын хэсэг:					
Үндэслэх баримтын нэр:	бичиг	он сар, дугаар			Тэмдэглэгээ

Маягт Тамга

Дарга...../Овог, нэр/

Гарын үсэг

Нягтлан бодогч...../ Овог, нэр/

оны сарын өдөр

тэмдэг, гарын үсэг

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medecelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 3.75

**Индекс:** 200003